

**АРХАНГАЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2019 ОНЫ
5 ДУГААР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар

**Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл
ажиллагааны мэдээлэл**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь заалт, Засгийн газрын зөвлөмжийн хүрээнд сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, багийн иргэдийн Нийтийн Хурлыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, үйл ажиллагаанд нь дэмжлэг, туслалцаа үзүүлэх чиглэлээр ажиллах ажлын хэсгийг аймгийн ИТХ-ын даргын захирамжаар байгуулж, ажлын удирдамж батлууллаа.

Удирдамжийн хүрээнд 12 сумын 33 багт ажиллаж багийн иргэдийн Нийтийн Хуралд ажиглагчийн байр сууринаас оролцож, мэргэжил арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, сумдын ИТХ-ын дарга, нарийн бичгийн дарга нарын ажил байдалтай нь танилцаж зөвлөмж өгсөн.

Аймгийн Засаг даргын удирдамжийн дагуу төрийн байгууллаууд сум, багт ажиллах үеэр иргэдийн хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, мэдээ, мэдээллээр хангах зорилгоор багийн иргэдийн Нийтийн Хурал, Засаг даргын бүрэн эрх, хуралдааны үлгэрчилсэн дэг, Нийгмийн даатгал, Нийгмийн халамжийн тухай хуулийн холбогдох заалтуудыг тусгасан “Иргэн таны эрх зүйн туслагч” нэртэй гарын авлагыг бэлтгэн “Жэрэс” олон улсын байгууллагын санхүүжилтээр хэвлүүлж 33 багийн 3000 гаруй иргэнд түгээсэн.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны мэдээлэл

2019 онд улсын төсвийн хөрөнгөөр нийт 144.915.7 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 54 төсөл арга хэмжээ хэрэгжинэ. Үүнээс 2019 онд 42.262.3 сая төгрөгөөр санхүүжинэ. Аймгийн авто замын сангийн хөрөнгө оруулалалтаар 5 төсөл арга хэмжээнд 275.6 сая төгрөг батлагдсанаас 4 төсөл арга хэмжээ нь шинээр хэрэгжих 1 төсөл арга хэмжээ нь урд оны дутуу санхүүжилт байна.

Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 7.302.6 сая төсөвт өртөг бүхий 26 төсөл арга хэмжээ хэрэгжинэ. Үүнээс 2019 онд 3.011.6 сая төгрөгөөр санхүүжинэ. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 3 төсөл арга хэмжээнд 132.7 сая төгрөг үүнээс барилга байгууламж 120.0 сая төгрөг, тоног төхөөрөмж 12.7 сая төгрөг тус тус тусгагдаад байна.

Аймгийн удирдах ажилтны ээлжит шуурхай зөвлөгөөнийг 5-р сарын 30-ны өдрийн 14.00 цагт аймгийн ЗДТГ-ын VIP танхимд зохион байгууллаа. Зөвлөгөөнд 51 удирдах ажилтан оролцохоос аймгийн ЗДТГ-ын нэгжийн дарга 6, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагийн дарга 11, төрийн өмчит аж ахуйн нэгж, байгууллагын дарга, сумын Засаг дарга 10, нийт 27 удирдах ажилтан оролцож, ирц 52.9 хувь байлаа. 11 агентлаг, хэлтсийн дарга нар албан томилолтоор явсан учраас шуурхай зөвлөгөөнд оролцоогүй болно.

Зөвлөгөөний үеэр аймгийн ЗДТГ-ын ХШҮДАХ-ээс 2019 оны 4-р сарын 25-ны өдрийн шуурхай зөвлөгөөний үеэр аймгийн Засаг даргаас өгсөн 15 үүрэг даалгаврын биелэлтийн явцыг танилцуулж, Онцгой байдлын газар, Эрүүл мэндийн газар, Боловсрол, соёл урлагийн газар, Ус, цаг уур, орчны шинжилгээний төвөөс цаг үеийн болон үйл ажиллагааны талаар мэдээлэл хийв.

Энэ удаагийн зөвлөгөөнөөр аймгийн Засаг даргаас цаашид эрчимжүүлж, сайжруулах ажил арга хэмжээний талаар 5 төрлийн үүрэг даалгаврыг байгууллагын дарга, сумдын Засаг дарга нарт өглөө.

Засгийн газрын 2019 оны 23 дугаар тогтоолоор баталсан "Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил"-ийн хүрээнд аймгийн ЗДТГ-аас "Тогтвортой амьжиргаа-3" төсөлтэй хамтран "Иргэдийн оролцоот багийн хөгжил" төслийг хэрэгжүүлж алслагдсан багийн төвүүдэд хүрч ажиллалаа.

Засгийн газрын болон аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, иргэдэд нэн шаардлагатай төрийн үйлчилгээг нэг дороос чирэгдэлгүй, шуурхай хүргэх, шинэчлэн батлагдсан хууль, журмыг иргэдэд таниулах, сурталчлах зорилгоор явуулын нэг цонхны үйлчилгээг 5-р сарын 1-нээс 25-ны хооронд Эрдэнэбулган, Ихтамир, Чулуут, Өндөр-Улаан, Цахир, Хангай, Тариат, Булган, Эрдэнэмандал, Цэцэрлэг, Жаргалант, Хайрхан гэсэн 12 сумын нийт 32 багийн 4500 гаруй иргэнд явуулын нэг цонхны үйлчилгээг үзүүллээ.

Явуулын нэг цонхны үйлчилгээнд Нийгмийн даатгалын хэлтэс, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Улсын бүртгэлийн хэлтэс, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Хөгжимт драмын театр, Нэгдсэн эмнэлэг, Архивын тасаг зэрэг байгууллагууд оролцож 10 гаруй төрлийн үйлчилгээг иргэдэд үзүүлсэн.

Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг 6-р сард Архангай аймагт явагдахтай холбогдуулан үзлэгийн бэлтгэл ажлын хүрээнд 5-р сарын 17-ны өдөр аймгийн ЗДТГ-ын Хууль эрх зүйн хэлтэс, Архивын тасгаас аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, сумдын ЗДТГ, төсвийн байгууллагуудын архив, бичиг хэргийн ажилтнуудын дунд сургалт зохион байгуулж улсын үзлэгт бэлтгэх чиглэл, архив, албан хэрэг хөтлөлтийн ажлын зохион байгуулалт, захирамжлалын баримт бичиг зохион бүрдүүлэх гэсэн сэдвүүдээр оролцогчдод мэдээлэл өгсөн.

Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан "Ирээдүй 1+1" хөтөлбөрийн хүрээнд "Хүүхдийн урлаг, спортын наадам"-ыг 5-р сарын 10,11-ний өдрүүдэд Цэцэрлэг хотноо зохион байгууллаа. Урлаг спортын наадамд 19 сумын 24 ерөнхий боловсролын сургууль, 34 хүүхдийн цэцэрлэгийн 2-18 насны нийт 2500 гаруй хүүхэд урлагийн 5, спортын 7 төрлөөр авьяас чадвар, хүч чадлаа сорин өрсөлдөж шилдгүүдээ шалгаруулсан байна.

Урлагийн төрөлд "Шилдэг Сургууль, Цэцэрлэг"-ээр Эрдэнэбулган сумын 1, 4-р сургуулиуд, Хүүхдийн 2-р цэцэрлэг, Өндөр-Улаан сумын Хүүхдийн цэцэрлэг шалгарсан бол "Шилдэг багш"-аар Өндөр-Улаан сумын ЕБС-ийн багш Д. Алтанхундага тодорч "Шилдэг үзүүлбэр"-ээр Хотонт сумын "Дэлбээ" хамтлаг "Гранпри" шагналын эзэн боллоо.

Спортын төрөлд “Шилдэг сургууль”-иар Эрдэнэбулган сумын 1-р сургууль, Спортын төрөлжсөн сургалттай сургууль шалгарсан бол “Шилдэг багш”-аар Спортын төрөлжсөн сургалттай сургуулийн багш Б.Батдэлгэр шалгарлаа.

Аймгийн үйлдвэрлэл эрхлэгчдийн зөвлөгөөнийг 5-р сарын 09-ний өдөр Цэцэрлэг хотод зохион байгууллаа. Тус зөвлөгөөнд хүнс, хөнгөн үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаа эрхэлж буй 18 сумын 145 иргэн, аж ахуйн нэгжийн төлөөлөл оролцсон юм.

5-р сарын 9-ний өдөр “Архангайд үйлдвэрлэв” худалдааны төвийн нээлтийн ажиллагааг зохион байгуулж 2700м² талбай бүхий 140 ажлын байрыг бий болголоо.

Засгийн газраас хэрэгжүүлж буй 3 жилийн хугацаатай судалгааны ажлын хүрээнд Үндэсний хөгжлийн газраас аймгийн ЗДТГ-тай хамтран бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хэлэлцүүлгийг Архангай аймагт 5-р сарын 10-ны өдөр зохион байгууллаа. Хэлэлцүүлэгт Үндэсний хөгжлийн газар, Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг, Жайка төслийн баг болон 19 сумын төлөөлөл оролцсон.

Хоёр. Эдийн засаг, төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд Татвар төлөлтийн талаар

2019 оны 5-р сард хүлээгдэж буй гүйцэтгэлээр улсын төсвийн болон орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө 100 хувьтай байна.

Тайлант хугацаанд 22 иргэн, аж ахуйн нэгжид тендерт оролцох виз хїссэн, зээл авах, бусад төрлїдээр лавлагаа тодорхойлолт гаргаж, цахимаар ирүүлсэн тайлан засварлах, хуулийн хугацаа сунгуулах, тоон гарын үсэг авах зэрэг 881 хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн байна. Цахим тайлангийн системд нэвтрэх хүчинтэй хугацаа дууссан 230 аж ахуйн нэгж байгууллагын цахимд нэвтрэх нууц үгийг дахин олгосон.

“Татвар төлөгчдийн өдрүүд”-ийг Оатварын ерөнхий газраас өдүжүсүі оаөдәаіæ аїөіі хэлтсийн даргүі бадәөһаі төлөвлөгөөний дагуу “Татвар хөгжлийн үндэс” одәаі аїд тэмдэглэн өнгөрүүлээ. Тәдәад о°ө°ә÷әәеі °әдүжүсүі арга хэмжээнд хэлтсийн дарга, аймгийн Засаг даргын Тамгын газрын удирдлагууд, 160 аадбөе өдәүі, аæ адоөі іүәæ, ааеәбөөәабоа оролцлоо.

Санхүүгийн хяналтын чиглэлээр

Санхүүгийн хяналт, аудитын албаны 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд батлагдсан удирдамжийн дагуу аймгийн Биеийн тамир, спортын газрын 2014-2018 оны үйл ажиллагаанд аудит, хяналт шалгалтыг улсын байцаагчийн хууль тогтоомжоор олгогдсон эрх, үүргийн хүрээнд хийж гүйцэтгэлээ.

Мөн 2019 оны эхний 5 сарын байдлаар Эрдэнэмандал, Жаргалант, Цэцэрлэг зэрэг хойд чиглэлийн сумдын төрийн байгууллагуудын 2017-2018 үйл ажиллагаанд төлөвлөгөөт хяналт шалгалт хийгдэж байна.

Орон нутгийн өмч, худалдан авах ажиллагааны чиглэлээр

Орон нутгийн өмчит 52 төсөвт байгууллагад 182.2 сая төг-ийн үндсэн хөрөнгө худалдан авах, 1 төсөвт байгууллагад 68 нэрийн 6.9 сая төг-ийн өртөг бүхий үндсэн хөрөнгө данснаас хасах зөвшөөрлийг тус тус олгосон байна.

Гурав. Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд

Иргэний бүртгэлийн чиглэлээр

- Шинээр төрсөн хүүхдээ бүртгүүлсэн төрөлт – 168
- Гэрлэлтийн бүртгэл - 51
- Гэрлэлт цуцалсаны бүртгэл - 2
- Хүүхэд үрчлэлтийн бүртгэл – 6
- Эцэг тогтоосны бүртгэл-16
- Овог эцэг /эх/-ийн нэр, нэр өөрчилсөний бүртгэл - 12
- Нас баралтын бүртгэл - 34
- Шинээр иргэний үнэмлэх олгосон - 96
- Дахин олгосон - 66
- Иргэний үнэмлэхний хугацаа дуусч солиулсан – 200
- Үндэсний энгийн гадаад паспорт-146
- Шилжилт хөдөлгөөн-176
- Иргэнд - 545 лавлагаа
Хóóëü õýíàèòüí ààéãóóèèääää - 62 èàâèагаа

Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн чиглэлээр

- Газар өмчлөх эрхийн анхны бүртгэл – 19
- Үл хөдлөх хөрөнгө өмчлөх эрхийн анхны бүртгэл - 14
- Шинээр бүртгүүлсэн орон сууцны бүртгэл – 0
- Газар эзэмших эрхийн анхны бүртгэл – 0
- Арилжааны гэрээ – 2
- Худалдах худалдан авах гэрээ – 57
- Бэлэглэлийн гэрээ – 13
- Барьцааны эрхийн бүртгэл –257
- Өв залгамжлал – 5
- Хамтран өмчлөгч өөрчлөгдөх – 6
- Лавлагаа – 8
- Бусад эрхийн бүртгэл – 3

Хóóëü õýíàèòüí ààéãóóèèääää íèéò 17 èàâèääääää ãàðääí õçðãççèñýí ààéíà. Дээрх бүртгэлүүдийг хийж улсын төсөвт үйлчилгээний хөлс 3167027 тэмдэгтийн хураамжид 31800 төгрөг, үл хөдлөх хөрөнгө худалдсанаас оруулсан татварын орлого 7673200 төгрөг төвлөрүүлсэн байна.

Хуулийн этгээдийн чиглэлээр

- Шинэ-8
- Өөрчлөлт-18
- Тамга тэмдэгний хяналтын дугаар олгосон-19

Аймгийн Мэргэжлийн хяналтын газраас 5 сумын 59 объектод хяналт шалгалтын ажил хийж, 21 нэр төрлийн 168 ширхэг чанар аюулгүй байдлын шаардлага хангахгүй хүнсний бүтээгдэхүүнийг буцаан татуулж, 1 аж ахуйн нэгжид 500 мянган төгрөгний торгуулийн арга хэмжээ ногдууллаа.

Шүүхийн шинжилгээний алба криминалистикийн шинжилгээ 3, хэргийн газрын үзлэгээр илрүүлж бэхжүүлсэн ул мөр, эд мөрийн баримт 39, шүүх эмнэлгийн шинжилгээ 74, тусгай шинжилгээ 12-ыг тус тус хийсэн байна.

Аймгийн хэмжээнд 2019 оны 5-р сард нийт 266 гэмт хэрэг гарсны дотор хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 67, хулгайлах гэмт хэрэг 112, үүний дотор малын хулгайн гэмт хэрэг 65 гарсан бөгөөд гэмт хэргийн илрүүлэлтийн хувь дунджаар 34.6 хувь байна.

Аймгийн хэмжээнд 5-р сард гамшиг осол, аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой ослын дуудлага нийт 14 удаа ирсэнээс, объектын гал түймрийн дуудлага 3, гал түймрийн зөрчлийн дуудлага 6, Эрэн хайх аврах ажиллагаа 4, мал амьтны гоц халдварт өвчин гарсан мэдээлэл 1 удаа тус тус ирсэн байна.

Гамшгаас хамгаалах команд штабын сургуулийг Хайрхан, Өлзийт суманд аймгийн Эрүүл мэндийн алба, Мал эмнэлгийн алба, Улаан загалмайн хороотой хамтран зохион байгуулж сумын онцгой комиссын 35, мэргэжлийн ангийн 148, оюутан сурагч 998-ийг хамруулж, удирдах албан тушаалтны сургалтыг 1 удаа 25 хүнд, ажилтны сургалтыг 4 удаа 138 албан хаагчид, мэргэжлийн ангийн сургалтыг 1 удаа 19 хүнд нийт 1344 хүнд ой хээрийн болон объектын гал түймэр, газар хөдлөлт, үер, усны осол, мал амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 39 цагийн дадлагын, 25 цагийн танхимын сургалт зохион байгууллаа.

Архангай аймаг дахь Шүүхийн шийдвэргүйцэтгэх газарт 1771461.9 төгрөгийн мөнгөн дүн бүхий 448 гүйцэтгэх баримт бичиг ирснээс шийдвэр гүйцэтгэх бодит биелэлтийн хувь 32.8, мөнгөн дүнгийн дундаж үзүүлэлт 17 байна.

Стандарт, хэмжил зүйн хэлтэс Массын хэмжлээр Өндөр-Уулаан, Чулуут, Хангай, Цахир, Тариат сумдын аж ахуйн тооцоонд ашиглаж байгаа 52 ш жин хэмжүүрт улсын баталгаажуулалт хийлээ. Эзэлхүүний баталгаажуулалтаар Тариат, Чулуут, Цахир, Хангай, Өндөрүлаан сумдын ШТС ын 21 ш шатахуун түгээгүүрийн шингэн хэмжигч баталгаажуулалтанд хамрууллаа.

Аймгийн баталгаажуулалтын зөвлөлийн 5 удаагийн хурлаар аж ахуйн нэгж, иргэдийн тохирлын гэрчилгээ авахаар ирүүлсэн 107 өргөдөл хүсэлтийг хэлэлцэж 103 хүсэлтэд тохирлын гэрчилгээ шинээр олгох, сунгахаар шийдвэрлэсэн байна

Дөрөв. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд Боловсролын чиглэлээр

Эрдэнэбулган сумын хувийн хэвшлийн “Эрдэм”, “Ирвэс лицей”, “Гурвантамир” сургуулиуд, Ихтамир, Булган сумдын ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэг, соёлын төвүүдийн үйл ажиллагаанд зөвлөн туслах ажлыг хийж гүйцэтгэлээ.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, “Боловсрол” телевизтэй хамтран ЕБС-ийн бага ангийн багшийн ажил, мэргэжлийн онцлогийг нийгэмд таниулах, шилдэг арга зүй, ур чадвартай манлайлагч багш нарыг шалгаруулах зорилготой “Би багш” шоу нэвтрүүлгийг зохион байгуулах удирдамжийг аймгийн 30 сургуульд танилцуулан чиглэл өгч ажиллалаа. Энэхүү уралдааны эхний шатыг ерөнхий боловсролын сургууль дээрээ зохион байгуулж шалгарсан тус бүр нэг багшийн бичлэгийг 13 сургуулиас ирүүлсэн. БСУГ-аас уг шоунд оролцогчдыг шалгаруулах

ажлын хэсгийг БСУГ-ын даргын 2019 оны 05 сарын 08 өдрийн а/15 тоот тушаалаар 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж

а) Асуудлаа тодорхойлсон байдал,

б) Асуудлаа шийдсэн арга зам

в) Зохион байгуулалт

г) Үр дүн

д) Арга хэлбэр гэсэн 5 шалгуураар нийт 13 бичлэг тус бүртэй танилцаж Эрдэнэбулган сумын 3-р сургуулийн багш Н.Туяацэцэг, 4-р сургуулийн багш С.Батчимэг, Ирээдүй цогцолбор сургуулийн багш В.Оюунчимэг нарыг шалгарууллаа.

Аймгийн ЭМГ, БСУГ хамтран 2019 оны 5-р сарын 01-ний өдөр Эрүүл мэнд хичээлийн VII олимпиадыг зохион байгуулсан бөгөөд ЕБС-ийн 8, 10, 11-р ангийн нийт 75 сурагчид эрүүл мэндийн хичээлийн 19 багш оролцлоо. Энэхүү олимпиадын сурагчдын сэдвийг “ФЮЧЕРСКҮҮЛ МОНГОЛИА” ХХК-ны шалгалтын хариу засах программ болох “Remark Office OMR”-ыг ашигласан.

2019 оны 5, 9, 12 ангиудын төгсөх ангийн Улсын шалгалтын үйл ажиллагаа 2019 оны 5-р сарын 27-ноос эхэлж, хуваарийн дагуу шалгалт авч эхлэх бэлтгэлийг хангаад байна. Энэхүү шалгалтуудын блюпринт, даалгаврын сан нь Боловсролын үнэлгээний төвийн <http://itembank.eec.mn/> сайтад бага боловсролын 3 хичээлээр нийт 1875 даалгавар, суурь боловсролын 10 хичээлээр 5888 даалгавар, бүрэн дунд боловсролын 10 хичээлээр 6780 даалгаврыг байршуулаад байна.

Соёл урлагийн чиглэлээр

Аймгийн Нийтийн номын сан нийтийн уншлагын танхимаар 37 уншигч шинээр бүртгэж, 1684 ирэгсэдэд 1612 ном, 259 сонин, 23 сэтгүүлээр, хүүхдийн уншлагын танхимаар 9 уншигч шинээр бүртгэж, 1873 ирэгсэдэд, 3040 номоор, гэрээр ном олгох үйлчилгээгээр 132 ирэгсэдэд 192 ном, 120 ширхэг сонин олгож үйлчилсэн байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2003 оны 105 дугаар зарлигийг хэрэгжүүлэх, Үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх, үндэсний бичиг соёлоороо бахархах үзэл, ухамсрыг олон түмний оюун санаанд төлөвшүүлэх, сурах, судлах эрмэлзэл төрүүлэх, байгаль орчноо хайрлан хамгаалах өв уламжлалыг сэргээх, сурталчлан таниулах, эх оронч, хүмүүнлэг үзлийг төлөвшүүлэх зорилгоор “Үндэсний бичиг үсгийн баяр-2019” арга хэмжээг 2019 оны 05 дугаар сарын 11-ны өдөр аймгийн ЗДТГ, аймгийн Боловсрол, соёл, урлагийн газар, аймгийн Нийтийн номын сан хамтран зохион байгууллаа. “Үндэсний бичиг үсгийн баяр”-ын хүрээнд Зөв сайхан бичигтэн, Түргэн уншлагын уралдаанууд, Уран бичлэгийн үзэсгэлэн, Зохиолч -Уншигчдийн уулзалт болон Жамъянгарав ба утга зохиол эрдэм шинжилгээний хурлын” арга хэмжээг зохион байгуулсан.

Жил бүрийн 5-р сарын 18-нд тэмдэглэн өнгөрүүлдэг Олон улсын музейн өдрийг угтан Төвшрүүлэх, Булган сумдын Соёлын төвүүдтэй хамтран тус сумын Ерөнхий боловсролын сургуулийн 6,7-р ангийн 38 сурагчид дунд "Түүхийн жимээр-2" танин мэдэхүйн аялалыг Майдар бурхан, Хүслийн хад гэсэн маршрутаар зохион явуулж, сурагчдын дунд хөгжөөнт тоглоом тоглуулан, түүх, соёлын дурсгал гэж юу болох, тэдгээртэй хэрхэн харьцах, Заяын хүрээний үүсэл, хөгжил түүхийг сурагчдад

ойлгуулан таниулж, түүхийн ач холбогдол зэргийг тайлбарлан тэдний түүхийн мэдлэгийг дээшлүүллээ.

Олон улсын музей өдөрт зориулан "Музей-нийгмийн соёлын төв: Уламжлалаа ирээдүйд" сэдвийн дор "Миний бахархал Архангай" боловсролын ажлыг Ерөнхий боловсролын Лаборатори I сургуулийн 7-р анги, Хүмүүн цогцолбор II сургуулийн 8, 9-р ангийн нийт 95 сурагчдад зохион байгуулж, "Миний Архангай" уламжлалт тоглоом наадгайгаар дамжуулан нутаг, уул усныхаа нэр болон амьтдын талаар хичээл орлоо.

Эрүүл мэндийн чиглэлээр

Аймгийн Нэгдсэн эмнэлгээс "Байгууллагын итгэмжлэгдсэн мэргэжилтэн-2019" шалгаруулах уралдаанд Нэгдсэн эмнэлгийн бүх тасаг нэгжийн нийт 147 сувилагч тусгай мэргэжилтэн онолын шалгалтыг 100 тестээр /чиглэл чиглэлээр тест боловсруулан / гардангийн шалгалтыг яаралтай тусламж, зөвлөгөө өгөх, гардан үйлдэл чиглээр / уралдааныг зохион байгуулж дүгнэн 30 мэргэжилтэнг 5-20 хувийн ур чадварын нэмэгдэл цалин олгосон байна.

"Улаанбурхан өвчинд цэг тавъя" уриан дор дархлаажуулалтын 10 хоногийг зохион байгуулав. 10 хоногийн хүрээнд улаанбурхан, улаанууд өвчний эсрэг нэмэлт дархлаажуулалтанд хамрагдах ЕБС-ийн 10-18 насны хүүхдүүдийг дархлаажуулалтанд хамруулахад сургуулийн үүрэг оролцооны талаар Эрдэнэбулган сумын бүх ЕБС-ийн ангийн багш, сургуулийн захирал, нийгмийн ажилтан, эмч нарыг оролцуулан мэдээлэл хийв. Бүх сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн дарга, вакцинаруудад нэмэлт дархлаажуулалтыг зохион байгуулах аргазүйн сургалтыг зохион байгуулав. Улаанбурхан, улаанууд өвчний эсрэг нэмэлт дархлаажуулалтанд 10-18 насны 10494 хүүхдийг буюу 87 хувийг хамруулаад байна.

Засгийн Газрын 2018 оны 255 дугаар тогтоолоор батлагдсан "Эрүүл шүд-Эрүүл хүүхэд" үндэсний хөтөлбөрийн нээлтийг аймгийн Засаг даргын тамгын газар, Нэгдсэн эмнэлэг, шүдний хувийн хэвшлийн эмнэлэг, өрхийн эрүүл мэндийн төв, Боловсрол соёл урлагийн газар, сургууль, цэцэрлэгийн удирдлагуудын оролцоог ханган зохион байгуулж, тус хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд боловсролын салбар, Нэгдсэн эмнэлэг, сум, өрхийн эрүүл мэндийн төв, хувийн хэвшлийн шүдний эмнэлгүүдийн үүрэг, оролцооны талаар мэдээлэл хийлээ.

"Иргэн би аврагч" өртөөчилсэн үзүүлэх сургалт, өдөрлөгийг зохион байгуулан иргэдэд осол гэмтлийн үед баримтлах зарчим, амилуулах суурь тусламж, түлэгдлийн үеийн анхны тусламж, хугалын үеийн анхны тусламж, цус алдалтын үеийн анхны тусламжийн талаар мэдээлэл өгсөн.

Эрүүл мэндийн байгууллагууд нийгмийн эрүүл мэндэд сувилагч тусгай мэргэжилтний оролцоог нэмэгдүүлэх үүднээс мэдээлэл сургалт сурталчилгааг тэмцээн, сургалт, үзлэг, бие бялдрын түвшин тогтоох зэрэг олон хэлбэрээр зохион байгуулан 1000 гаруй иргэдийг хамруулсан.

Биеийн тамир, спортын чиглэлээр

Чөлөөт бөхийн 2019 оны залуучуудын Улсын аварга шалгаруулах тэмцээн 5-р сарын 23-25-ны өдрүүдэд Цэцэрлэг хотод боллоо. Эрэгтэйчүүдийн 38, эмэгтэйчүүдийн 13 дахь удаагийн тэмцээнийг Архангай аймгийн чөлөөт бөхийн холбоо, Биеийн тамир

спортын газар, “Арж” групп, Монголын чөлөөт бөхийн холбоо хамтран зохион байгуулсан бөгөөд тэмцээнд нийслэл, дүүрэг, хөдөө, орон нутгийн 25 байгууллагын 265 гаруй тамирчин эрэгтэй, эмэгтэйчүүдийн тус бүр 10 жинд хурд, хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдсөнөөс эрэгтэйчүүдийн багийн дүнгээр гавьяат дасгалжуулагч Ц.Баярсайхан дасгалжуулагчтай Дархан-Уул аймгийн “Хасу-Мегастарс” клуб тэргүүлж, С.Мөнхдуулдах дасгалжуулагчтай Баянхонгор аймгийн “Хонгор нутаг” дэвжээ удаалж, ОУХМ Д.Гомбодорж дасгалжуулагчтай “Хангай хүчтэн” клуб гуравдугаар байрт оров. Эмэгтэйчүүдийн багийн дүнгээр гавьяат дасгалжуулагч Т.Сүхбаатар, М.Мөнхбат дасгалжуулагчтай “Женко” клуб, гавьяат дасгалжуулагч Ц.Хосбаяр дасгалжуулагчтай “Алдар” спорт хороо, спортын мастер Ё.Батдархан дасгалжуулагчтай Дархан-Уул аймаг, “Хасу-Мегастарс” клуб эхний гурван байрыг эзэллээ.

Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын чиглэлээр

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэн, байнгын асаргаанд байдаг хүүхдээ асарч буй эцэг эхийн аж ахуй, өрхийн үйлдвэрлэлээ хөгжүүлэх бизнес төслийг орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр ил тод нээлттэй зарлан хөгжлийн бэрхшээлтэй иргэний 31 төслийг хүлээн авсан. Төсөл сонгон шалгаруулах ажлын хэсгийг бүрэлдэхүүнийг газрын даргын 2019 оны А/08 тоот тушаалаар байгуулан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон байнгын асаргаанд буй хүүхдээ асарч буй хувиараа хөдөлмөр эрхлэгч эцэг, эхийн бизнес төслийг сонгон шалгаруулах ажлын хэсгийн хурлыг 2 удаа хуралдуулан ажлын хэсгийн бүрэлдэхүүн төсөл өгсөн өрх бүрээр явж төслийн үйл ажиллагаатай танилцан 2019 оны 5-р сарын 16-ны хурлын шийдвэрээр 12 иргэний төсөлд 55.000,000 төгрөгийн эргэн төлөлттэй санхүүжилтийг олгож байнгын ажлын байраар хангалаа.

Архангай аймгийн хэмжээнд Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний хамт олны бүлэг бүрдүүлж орлогын эх үүсвэртэй болгох бүлгийн төслийг зарлан хүнсний ногоо, суран эдлэл, сүү цагаан идээ, оёдол, гутал засвар, модон эдлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах нийт 12 сумын 14 төслийг сонгон шалгаруулж гэрээ байгуулан 14.0 сая төгрөгөөр санхүүжүүлсэн. Бүлгийн төсөлд зорилтот бүлгийн 29 өрхийн 34 иргэн хамрагдан өрхийн орлогоо нэмэгдүүлэхээр ажиллаж байна.

Нийгмийн даатгалын санд 2019 оны 5-р сард нийт 6,09 тэрбум төгрөгийн шимтгэлийн орлого төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 135 хувиар биелүүлсэн байна. Давхардсан тоогоор 14,2 мянган иргэний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн зардалд нийт 13.08 тэрбум төгрөг зарцуулжээ. Улсын төсвөөс 1995 оноос өмнө тэтгэвэр тогтоолгосон иргэдийн болон цэргийн тэтгэвэрт 1908,6 сая төгрөгийг нийгмийн даатгалын санд шилжүүлжээ.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн чиглэлээр

Цэнхэр, Өлзийт, Өгийнуур, Хашаат, Хотонт, Төвшрүүлэх, Батцэнгэл 7 суманд 9 чиглэлийн арга хэмжээнд 689 хүүхэд, 1113 насанд хүрэгчид, нийтдээ 1802 хүнийг хамруулсан. Хүүхдийн төлөө зөвлөл, Хамтарсан баг, Залуучуудын хөгжлийг дэмжих салбар зөвлөлийн дарга, гишүүдийн уулзалтыг зохион байгуулж, цаашид хэрхэн ажиллах талаар заавар, зөвлөмж өгсөн.

Зорилтот бүлгийн 14 гэр бүлийн нөхцөл байдалтай танилцаж, цаашид үзүүлэх хариу үйлчилгээний талаар хамтарсан багийн гишүүдэд арга зүйн дэмжлэг, гэр бүлийн гишүүд болох 16 хүүхэд, 14 эцэг эх, асран хамгаалагчдад хүүхэд хамгааллын болон бусад мэдээлэл өглөө. Сурагчдын дотуур байрны 8 багш 101 хүүхэдтэй бүлгийн ярилцлага болон асуулгын аргаар судалгаа авч, судалгааны дүнг зөвлөмжид тусгасан. Эцэг эх, асран хамгаалагчид, сурагчид, багш, ажилтан, бусад төрийн албан хаагчдад зориулсан дагнасан сургалтанд 314 эцэг эх, асран хамгаалагч, 532 сурагчид 340 төрийн албан хаагч, нийтдээ 1186 хүн хамрагдсан.

Тав. Хөдөө аж ахуйн бодлогын хүрээнд

Мал аж ахуй

Архангай аймгийн хэмжээнд 2019 онд нийт 2365134 хээлтэгч мал төллөхөөс 5-р сарын 23- ны байдлаар 1850597 толгой мал төллөж аймгийн дүнгээр бод малын 47.4 хувь, бог малын 83.7 хувь ба нийт мал төллөлт 78.2 хувьтай байна. 1813621 толгой төл 98 хувьтай бойжиж байна.

Том малын зүй бус хорогдол 30482 толгой үүнээс тэмээ 1 толгой 0,1 , адуу 2098 толгой 0,6 хувь, үхэр 3218 толгой 0,5 хувь , хонь 15119 толгой 0,5 хувь , ямаа 10046 толгой 0.7 хувь, нийт малын 0,6 хувь нь хорогдсон байна.

Зургаа. Байгаль орчин, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийн салбарын бодлогын хүрээнд

Байгаль орчны чиглэлээр

Ойн тухай хуулийн 31 дүгээр зүйл, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 63 дугаар зарлигийг хэрэгжүүлэх, ойн сан, ойн зурвас, төв суурин газрын ногоон байгууламжийн талбайг нэмэгдүүлэх зорилгоор “Бүх нийтээр мод тарих үндэсний өдрийг зохион байгуулах тухай” аймгийн Засаг даргын 2019 оны А/202 дугаар захирамж гарган хэрэгжилтийг ханган ажиллалаа.

“Мод тарих үндэсний аян”-ныг аймгийн ЗДТГ, Сум дундын ойн анги, Цэцэрлэг хотын Хот тохижилт, төлөвлөлт, нийтийн аж ахуйн газар, сумдын Засаг даргын Тамгын газрууд хамтран 2019 оны 5-р сарын 09-нөөс 5-р сарын 20-ны өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулж нийт 23436 ширхэг мод, бут сөөг тарьсан байна.

Үүнээс 4682 ширхэг мод, 18754 ширхэг бут сөөгийг 151 аж ахуйн нэгж, байгууллагын 2371 иргэд оролцож 100 гаруй өрх эзэмшлийн хашаандаа 520 ширхэг жимс, жимсгэний мод, бутыг тарьсан байна. Цаг уурын нөхцөл байдалтай уялдуулан Цэцэрлэг хотын нийтийн эзэмшлийн гудамж, цэцэрлэгт хүрээлэн дэх 900 м2 талбайд цэцгийн мандал байгуулж, 2000 м2 талбайд зүлэгжүүлэлтийн ажлыг гүйцэтгэх юм.

“Архангай аймгийн тогтвортой хөгжлийн хэтийн зорилт 2026 бодлогын баримт бичиг”, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Архангай аймгийг нүүдлийн соёлын олон улсын төв болгон хөгжүүлэх 2019–2030 дунд хугацааны баримт бичиг, “Орхоны хөндийн бүс нутгийн аялал жуулчлалын стратеги - 2020”, Аймгийн аялал жуулчлалын дэд хөтөлбөрийг удирдлага болгон төрөөс аялал жуулчлалын чиглэлээр баримталж буй бодлого, төлөвлөлт, хууль эрхзүй, стандарт шаардлагууд болон аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн

болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хамтын ажиллагаа, уялдаа холбоог сайжруулах зорилго бүхий уулзалт хэлэлцүүлгийг зохион байгууллаа.

Уулзалт хэлэлцүүлэгт аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгж байгууллага, иргэн, төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөл, гар урлал, рашаан сувилал, малчдын нөхөрлөлийн төлөөлөл 111 хүн оролцлоо. Урилгаар Мэргэжлийн холбоодын зөвлөлийн дарга Д.Эрдэнэбат “Төр, хувийн хэвшлийн түншлэл” сэдвээр, Улаанбаатарын их сургуулийн Түүх археологийн тэнхимийн эрхлэгч Д.Эрдэнэбаатар “Архангай аймагт түүх археологийн аялал жуулчлалыг хөгжүүлэх боломж” сэдвээр тус тус илтгэл тавьлаа.

Барилга, дэд бүтцийн чиглэлээр

2019 онд улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 31581,3 сая төгрөгийн өртөг бүхий 63 объектийн ажилд захиалагчийн хяналт хэрэгжүүлэхээр төлөвлөгөө гарган ажиллаж байгаа бөгөөд Эрдэнэмандал сумын 15 ортой эмнэлэг, Хүүхэд залуучуудын Цэцэрлэгт хүрээлэнгийн зургийн даалгаврыг боловсруулсан.

Дараах барилгуудын барилгын ажлын гэрээг гүйцэтгэгч компаниудтай байгуулсан. Үүнд:

- ✓ Төвшрүүлэх сумын Баян-Өндөр багийн багийн төвийн барилга
- ✓ Өндөр-Улаан сумын Соёлын төвийн их засвар
- ✓ Чулуут сумын халуун ус багийн багийн төвийн барилга
- ✓ Батцэнгэл сумын Улаан-Чулуут багийн багийн төвийн барилга
- ✓ Өлзийт сумын Бодонт багийн багийн төвийн барилга
- ✓ Булган, Чулуут, Хангай, Цахир, Тариат, Өндөр-Улаан, Жаргалант, Ихтамир, сумдад хүүхдийн тоглоомын талбай модон цамхаг бүхий цогцолбор
- ✓ Цахир сумын 50 хүүхдийн дотуур байрны засвар
- ✓ Батцэнгэл сумын ЗДТГ-ын барилга

Долоо. Сум, орон нутгийн мэдээлэл

Жаргалант

5-р сарын 10-ны өдөр архивын улсын үзлэг болон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилтай холбогдуулж сумын ЗДТГ-ын албан хаагч, багийн Засаг дарга нарт Нутгийн захиргаа, эрх зүйн ажилтан “Тамга, тэмдэг, хэвлэмэл хуудастай холбоотой хууль тогтоомжийн танилцуулга, эрх зүйн зохицуулалт” сэдвээр, хэсгийн төлөөлөгч “Албан тушаалын гэмт хэрэг”-ийн талаар, Архив, бичиг хэргийн эрхлэгч “Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх заавар” сэдвээр тус тус сургалт хийсэн.